

БАТЛАВ  
МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ  
ДАРГА  ДӨТГОНСҮРЭН

**ОЛОН УЛСЫН ЧАНАРТАЙ ХУУРАЙ БООМТ БАЙГУУЛАХ ОЛОН ТӨРӨЛТ ТЭЭВРИЙН  
ХОЛБОЛТ, ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЭРЧИМЖЛИЙН СУДАЛГАА ХИЙХ /ХӨШИГИЙН  
ХӨНДИЙ, ТӨВ/ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 05 дугаар сарын 01

Дугаар 1...

Улаанбаатар хот

Судалгаа боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Их хурлаар 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр;</li><li>- Монгол Улсын Их хурлаар 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого;</li><li>- Монгол Улсын Их хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого";</li><li>- Зам, тээвэр хөгжлийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн "Монгол Улсын Далайн захиргааны 2024 оны орлого, зарлагын төлөвлөгөөг батлах тухай" А/13 дугаар тушаал;</li><li>- Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орон нутгийн зэрэглэлтэй "Шинэ Зуунмод" болон "Майдар" хотыг шинээр байгуулах тухай Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 14-ний өдрийн 55 дугаар тогтоол;</li><li>- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 143 тогтоолоор батлагдсан "Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө";</li><li>- Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд</li><li>- Монгол Улсын УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага";</li><li>- Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний концепци;</li></ul>
Судалгааны зорилго, ач холбогдол	<ul style="list-style-type: none"><li>- Төв аймгийн Хөшигийн Хөндийн нутаг дэвсгэрт байрлах "Чингис хаан" олон улсын нисэх буудлыг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах, олон төрөлт тээврийн холболт, замын хөдөлгөөний эрчимжлийн судалгаа хийж, төлөвлөлт болон урьдчилан шийдвэрлэх асуудлуудыг зөв оновчтой, дэс дараалалтайгаар гаргаж, дүгнэлт санал зөвлөмж боловсруулах</li></ul>
Байршил, газар нутгийн хэмжээ, хамрах хүрээ	<ul style="list-style-type: none"><li>- Төв аймгийн Хөшигийн Хөндийн нутаг дэвсгэрт байрлах "Чингис хаан" олон улсын нисэх буудлын орчмын бүс нутаг (Хамрах хүрээ: Улаанбаатар хот, Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сумын нутаг</li></ul>

	дэвсгэр)
Судалгааны ажлыг захиалагч байгууллага	Зам, тээвэр хөгжлийн яамны харьяа Монгол Улсын Далайн захиргаа
Судалгааны ажлыг гүйцэтгэх байгууллага	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу сонгон шалгаруулна
Судалгаанд шаардагдах хөрөнгө	Өөрийн хөрөнгө - 50,000,000 (Тавин сая) төгрөг
Судалгааны чиглэл, тайлангийн иж бүрдэл	<p>Судалгааны ажил нь Төв аймгийн Хөшигийн Хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг орчмын түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах, олон төрөлт тээврийн холболт, замын хөдөлгөөний эрчимжлийн судалгаа хийж тээврийн холболтын харилцан уялдааг бий болгоход чиглэгдсэн байна.</p> <p><b>Судалгааны хамрах хүрээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Далайд гарцгүй орны дамжин өнгөрөх хуурай боомтын ач холбогдол, Төв аймгийн бүс нутгийн зах зээл худалдааны эргэлтэд дүн шинжилгээ хийх;</li> <li>- Бүс нутгийн худалдааны одоогийн байдалд дүн шинжилгээ хийж 10-20 жилийн өсөлтийг тооцоолж хэтийн төлөвийг тодорхойлох;</li> <li>- Бүс нутгийн худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд Төв аймгийн Хөшигийн Хөндийн олон улсын чанартай хуурай боомтын ачаа тээврийн урсгалын нөлөөллийн судалгаа;</li> <li>- Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, Олон улсын авто тээврийн конвенц (TIR) зэрэг олон улсын холбогдох гэрээ конвенцуудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх;</li> <li>- Монгол, Орос, Хятад гурван улсын эдийн засгийн коридорын одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж БНХАУ-ын болон ОХУ-ын бүс нутгийн логиستيкийн сүлжээнд Хөшигийн Хөндийн хуурай боомтыг холбох гарцуудыг тодорхойлох;</li> <li>- Төв аймгийн Хөшигийн Хөндий нутаг дэвсгэрт “Чингис хаан” Олон улсын нисэх буудлыг түшиглэн байгуулах олон улсын чанартай “Хөшигийн Хөндий хуурай боомт” байгуулах зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох;</li> <li>- БНХАУ-ын туршлагаар ачаа барааг зөвхөн нэг цэгээс нөгөө цэг рүү ачих бүс нэг зангилаа хааб (hub)-аас дараагийн хааб хүртэл холимог тээвэр ашиглан зөөвөрлөх нь ашигтай гэж үзэж байгаа бөгөөд “Хөшигийн Хөндий хуурай боомт” -ыг бүс нутгийн зангилаа хааб болгон хөгжүүлэх өрсөлдөх</li> </ul>

чадварыг тодорхойлох;

- Олон улсын төмөр зам, авто зам, агаарын тээврийн салбарт гарч буй хөгжлийн чиг хандлага (тогтвортой байдал, олон улсын холболт, логистикийн ерөнхий шийдэл, найдвартай байдал, уян хатан байдал гэх мэт) талаарх судалгаа;
- Олон улсын агаарын тээвэр, авто зам, төмөр замын тээвэрлэлт дэх гаалийн дамжин өнгөрүүлэх журмыг хялбарчлах боломжийг олон улсын сайн туршлагыг судлах;
- Хөшигийн Хөндий нутаг дэвсгэр байгуулах олон улсын чанартай “Хөшигийн Хөндий хуурай боомт” байгуулах тээврийн дэд бүтцийн холболт, тэдгээрийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу дамжин өнгөрөх тээвэр, импорт, экспортын тээврийн олон төрөлт тээврийн холболт, замын хөдөлгөөний эрчимжлийн талаар судалгаа, шинжилгээ хийх;
- Монгол Улсын агаарын ачаа тээврийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, бүс нутгийн өсөн нэмэгдэж буй агаарын ачаа тээврийн зах зээлийн судалгаа болон хууль эрх зүйн орчны талаар судалгаа хийх ;
- Төв аймгийн Хөшигийн Хөндий нутаг дэвсгэрт “Чингис хаан” Олон улсын нисэх буудлыг түшиглэн байгуулах олон улсын чанартай “Хөшигийн Хөндий хуурай боомт”-ыг бүс нутгийн цахим худалдааны нэгдсэн сүлжээнд холбох нөхцөл боломжийн судалгаа;
- БНХАУ-ын Шинжаан Уйгурын Өрөмч хотын хуурай боомтын туршлагыг судлах;
- “Хөшигийн Хөндий хуурай боомт” -ын БНХАУ, ОХУ болон бүс нутгийн ижил төстэй хуурай боомтуудтай хатуу болон зөөлөн дэд бүтцээр холбох судалгаа;

**Судалгааны дүгнэлт, санал зөвлөмж:**

- Монгол, Орос, Хятад гурван улсын эдийн засгийн коридорын төв коридорт байрлах “Хөшигийн Хөндий хуурай боомт” байгуулах нөхцөл байдлын судалгааны дүгнэлт болон санал зөвлөмж;
- “Хөшигийн Хөндий хуурай боомт” байгуулахад бүс нутгийн болон хөрш орнуудын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны шинэ боломжуудын талаар зөвлөмж боловсруулах;
- Цахим худалдааг хөгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин, гааль, техник, тоног төхөөрөмж, дэд бүтэц, барилга байгууламжийн талаар олон улсын сайн туршлага, нутагшуулах чиглэлээр санал зөвлөмж;
- БНХАУ-ын болон бусад улс орнуудын хуурай боомт

	<p>хөгжүүлсэн сайн туршлагаар “Хөшигийн Хөндий хуурай боомт”-ыг хөгжүүлэх бизнес загвар хувилбарт санал зөвлөмж боловсруулах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төв аймгийн Хөшигийн Хөндий дэх “Чингис хаан” Олон улсын нисэх буудлыг түшиглэн байгуулах олон улсын чанартай хуурай боомтод байгуулах боломжтой үйлдвэрлэл болон экспортод гаргах уул уурхай бус бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээний талаарх санал, зөвлөмж;</li> <li>- Хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн санал зөвлөмж;</li> </ul>
Судалгааны ажлыг гүйцэтгэх арга аргачлал	- Судалгааны ажлын даалгаврын хүрээнд судалгааны нарийвчилсан төлөвлөгөөг баталгаажуулан ирүүлнэ.
Судалгааны ажлын тайланг хүлээн авах	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны ажлын тайланг ажлын даалгавартай нийцсэн эсэхийг хянаж хүлээн авна.</li> <li>- Судалгааны ажлын иж бүрдэл: Судалгааны холбогдох материал, тайлан, дүгнэлт, санал зөвлөмж, судалгааны танилцуулгын хамт захиалагчид гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</li> <li>- Судалгааны ажлын тайланг Монгол хэл дээр 2 хувь хэвлэж өгөхөөс гадна эх файлыг цахимаар хүлээлгэн өгнө.</li> </ul>
Судалгааны ажил эхлэх хугацаа	- Гэрээ байгуулагдаж 2 тал гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхэлнэ.
Судалааны ажлыг гүйцэтгэх хугацаа	- 30 хоног

**ХЯНАСАН:**


ХУУРАЙ БООМТ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ӨЛЗИЙБАЯР

**БОЛОВСРУУЛСАН:**

ХУУРАЙ БООМТ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН



С.БИЛЭГСАЙХАН